



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 06 сарын 04-ны
өдрийн 4216 дугаарт бүртгэв.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/138

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлэхийг Хэмжил зүйн хүрээлэн /Д.Дамбасүрэн/, Хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалтын газар /Л.Баярхүү/-т, хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлт, дотоод аудитын газар /Б.Ууганбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Бүртгэлийн дугаар 88

ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
тохируулагч агентлаг
СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын архлогч

Б.БИЛГҮҮН

2020 оны 06 сарын 04 ний өдөр

028014259

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2008 оны 06 сарын 04-ны өдрийн
А/138 дугаар тушаалын хавсралт 1


**ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙГ ҮЙЛДВЭРЛЭХ, ИМПОРТЛОХ,
СУУРИЛУУЛАХ, ЗАСВАРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ, ХЭМЖИЛ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН УЛСЫН НЭГДСЭН
САНД БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэ журмын зорилго нь хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах /цаашид “хэмжил зүйн үйл ажиллагаа” гэх/ аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шаардлагыг тогтоох, чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.
- 1.2 Энэ журмыг хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.

**Хоёр. Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх
аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шаардлага**

- 2.1 Ерөнхий шаардлага.
 - 2.1.1 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь хуулийн этгээд байх бөгөөд хариуцсан нэгж, орон тооны ажилтантай байна.
 - 2.1.2 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх чадавхаа үнэлүүлэх ажил, үйлчилгээ нь төлбөртэй ба холбогдох зардлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага бүрэн хариуцна.
 - 2.1.3 Аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 1-7 дугаар хавсралтын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх чадавхаа үнэлүүлэх хүсэлтээ албан бичгээр ирүүлнэ.
 - 2.1.4 Холбогдох хууль, тогтоомжийн дагуу татвар хураамжаа төлсөн, шүүхийн шийдвэрийн өр төлбөргүй байна.
- 2.2 Ажлын байр, орчны нөхцөлийн шаардлага
 - 2.2.1 Ажлын байр, орчны нөхцөл нь хэмжил зүйн үйл ажиллагааны хамрах хүрээний холбогдох стандарт, техникийн баримт бичиг, технологийн заавар, дүрэм, журамд заасан шаардлагыг хангасан байна.
 - 2.2.2 Хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж нь албан тасалгаанаас тусдаа өрөө, зориулалтын хэсэгтэй байна.
 - 2.2.3 Хэмжил зүйн үйл ажиллагаа нь хэмжлийн төрөл, зориулалт бүрээр тусгаарлагдсан өрөө, тасалгаатай байна.
- 2.3 Баримт бичгийн шаардлага
 - 2.3.1 Хэмжил зүйн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг бүрдүүлж, тэдгээрт нийцсэн технологийн заавар, аюулгүй ажиллагааны дүрэм, хэмжих хэрэгслийг худалдах, ашиглах болон санал гомдлыг шийдвэрлэх журам холбогдох бусад баримт бичгийг боловсруулан баталж, бүртгэл хөтөлж мөрдөнө.



- 2.3.2 Хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлэх тухай үйлдвэрлэгч болон албан ёсны борлуулагчтай гэрээ байгуулсан байна. Гэрээнд сэлбэг, хэрэгслээр хангаж ажиллах талаар тусгасан байна.
- 2.3.3 Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортолсон, худалдсан, ашигласан, суурилуулсан, засварласан болон холбогдох засвар, үйлчилгээний байгууллагыг сэлбэг хэрэгслээр хангаж ажилласан тухай бүртгэлтэй байна.

2.4 Хүний нөөцийн шаардлага

- 2.4.1 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн чадавхтай, батлагдсан ажлын байрны тодорхойлолттой байна. Үүнд:
- тухайн хэмжлийн төрөлд холбогдох мэргэжлийн болон хэмжил зүйн чиглэлээр мэргэшсэн инженер, техникийн 2-оос доошгүй ажилтан;
 - хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан.
- 2.4.2 Хэмжил зүйн ажилтан нь тухайн хэмжлийн төрлөөр хэмжил зүйн төв байгууллагын мэргэшүүлэх сургалтад 3 жил тутам хамрагдсан байна.

2.5.Эталон тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн шаардлага

- 2.5.1 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай эталон тоног төхөөрөмж, багаж, техник хэрэгслээр бүрэн хангагдсан байна.
- 2.5.2 Эталон тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл нь нарийвчлалын шаардлага хангасан, нэгж дамжуулалт болон шалгалт тохируулгад хамрагдсан, техник ашиглалтын бүртгэлтэй байна.
- 2.5.3 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүрээнд сэлбэг хэрэгслийн нөөцтэй байна.

Гурав.Үнэлгээний төрөл, үр дүн, хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй хугацаа

3.1 Үнэлгээний төрөл


- 3.1.1 **Анхдагч** үнэлгээгээр хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт анх гаргаж байгаа, мөн хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасагдсан аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг үндэслэн хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг тогтооно.
- 3.1.2 **Хамрах хүрээг өөрчлөх** үнэлгээгээр хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг үндэслэн хэмжлийн болон хэмжил зүйн үйл ажиллагааны төрөл, техникийн чадавхын өөрчлөлтийг үнэлж хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг тогтооно.
- 3.1.3 **Давтан** үнэлгээгээр хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг үндэслэн хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагын хэрэгжилтийг үнэлж хугацааг сунгах эсэхийг тогтооно.
- 3.1.4 **Магадлан** үнэлгээгээр эрх бүхий байгууллагаас, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжил зүйн үйл ажиллагааны хэрэгжилтийг магадлан тогтооно.

3.2 Үнэлгээний үр дүн.

- 3.2.1 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд хангалттай үнэлгээ өгнө.
- 3.2.2 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг хангаагүй тохиолдолд хангалтгүй дүн өгнө.

3.3.Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй хугацаа

- 3.3.1 Анхдагч болон хамрах хүрээг өөрчлөх үнэлгээнд хангалттай үнэлэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хугацаа 3 жил байна.



3.3.2 Давтан үнэлгээнд хангалттай үнэлэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хугацаа 5 хүртэл жил байна.

**Дөрөв. Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж,
байгууллагын чадавхыг үнэлэх, шийдвэр гаргах**


- 4.1 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн, нэгж, байгууллагын баримт бичгийн бүрдлийн үзлэгийг хэмжил зүйн төв байгууллагын холбогдох албан тушаалтан хийж, шаардлага хангасан тохиолдолд үнэлгээний ажлын хэсгийг хэмжил зүйн төв байгууллагын даргын шийдвэрээр томилох бөгөөд гишүүд нь тухайн хэмжлийн төрлөөр сургалтад хамрагдсан эсхүл хэмжил зүйн чиглэлээр мэргэшсэн байна.
- 4.2 Ажлын хэсэг үнэлгээ, дүгнэлтийг ажлын 20 хоногт багтаан гүйцэтгэх ба шаардлагатай тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагаас холбогдох нэмэлт баримт материалыг бүрдүүлэх, илэрсэн алдаа зөрчлийг залруулах талаар хугацаатай үүрэг өгнө. Энэ тохиолдолд үнэлгээ, дүгнэлт гаргах хугацааг түр зогсооно.
- 4.3 Анхдагч болон хамрах хүрээг өөрчлөх үнэлгээний ажлын хэсгийн тайлан, дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн тохиолдолд Хэмжил зүйн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар баталгаажуулна.
- 4.4 Давтан болон магадлан үнэлгээний ажлын хэсгийн тайлан, дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн тохиолдолд Хэмжил зүйн төв байгууллагын хэмжил зүйн асуудал хариуцсан дэд дарга болон холбогдох нэгжийн даргын санал, дүгнэлтийг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 4.5 Хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд ажлын хэсэг дүгнэлтийг аж ахуйн нэгж, байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

**Тав. Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж,
байгууллагыг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх,
бүртгэлээс хасах**

- 5.1 Анхдагч, давтан, хамрах хүрээг өөрчлөх үнэлгээнд хангалттай үнэлэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.
- 5.2 Хэмжил зүйн үйл ажиллагааны давтан үнэлгээнд хамрагдаагүй болон давтан, магадлан үнэлгээнд хангалтгүй дүгнэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагыг Хэмжил зүйн төв байгууллагын даргын тушаалаар хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасна.

Зургаа. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

- 6.1 Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, байршил, хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүний нөөцийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд Хэмжил зүйн төв байгууллагад ажлын 20 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.
- 6.2 Үйлдвэрлэсэн, импортолсон, засварласан хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулна. Шалгалт, баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийг суурилуулна.
- 6.3 Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг Хэмжил зүйн төв байгууллагад хагас, бүтэн жилээр албан бичгээр хүргүүлнэ.
- 6.4 Давтан үнэлгээнд хамрагдах тухай албан хүсэлтээ хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүчинтэй хугацаа дуусахаас ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө энэ журмын хавсралтын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж Хэмжил зүйн төв байгууллагад хүргүүлнэ.



6.5 Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасагдсан аж ахуйн нэгж, байгууллага нь гаргасан алдаа, зөрчлийг арилгасан тохиолдолд хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтээ Хэмжил зүйн төв байгууллагад хүргүүлж болно.

Долоо. Бусад

7.1 Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

--- 0 ---

Бүртгэлийн дугаар

ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
тохиргооларч агшны
СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын эрхлэгч
.....
2000 оны 06 сарын 04 ний өдөр

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
 2010 оны 06 сарын 04 -ны өдрийн
 А/138 дугаар тушаалын хавсралт 2

Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага хангасан
 тухай аж ахуйн нэгж, байгууллагын илтгэх хуудас

Хүсэлт гаргагч аж ахуйн нэгжийн нэр:
 Огноо:

Бүрдүүлэн хавсаргах бичиг баримт

№	Агуулга	Шаардлагын дагуу баримт бичгийг хавсаргасан байх
1	Албан бичиг бүхий хүсэлт /байгууллагын одоогийн хаяг, цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар тодорхой эсэх/	
	Өргөдлийн маягтаар хэмжил зүйн үйл ажиллагааны хамрах хүрээ, эталон, хэмжих хэрэгслийн хэмжил зүйн үзүүлэлт, үнэлгээ хийлгэх төрлийг тодорхойлсон байх	
	Холбогдох хавсралтыг бүрэн бөглөсөн байх	
	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	
	Байгууллагын товч танилцуулга	
2	Холбогдох хууль, тогтоомжийн дагуу татвар хураамжаа төлсөн, шүүхийн шийдвэрийн өр төлбөргүй тухай тодорхойлолт.	
	Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, байршил, хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх бүтцэд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр албан ёсоор мэдэгдсэн эсэх	
	Хэмжил зүйн үйл ажиллагааны хамрах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, хэмжих хэрэгслийн судалгаа, мэдээг хэмжил зүйн төв байгууллагад хагас, бүтэн жилээр хүргүүлсэн мэдээлэл /сүүлийн 3 жилийн ажлын тайлан/	
	Хэмжил зүйн үйл ажиллагаанд ашиглах хууль, холбогдох салбарын эрх зүйн баримт бичиг, стандарт	
	Хөдөлмөр аюулгүй ажиллагааны заавар, хуулбар	
3	Хэмжил зүйн үйл ажиллагааг эрхлэн явуулах хүний нөөцийн мэдээлэл:	
	Инженер, техникийн болон хөдөлмөр аюулгүй ажиллагааны ажилтны ажлын байрны тодорхойлолт	
	Боловсролын диплом, мэргэжил, мэргэшлийн гэрчилгээ, үнэмлэхийн хуулбар	
	Хэмжил зүйн сургалт, мэргэшлийн гэрчилгээний хуулбар	Бүртгэлийн дугаар 88
4	Үйлдвэрлэх:	
	Үйлдвэрлэлийн байр, өрөөний мэдээлэл, зураг	

ХУУЛБАР ҮНЭН
 Монгол улсын Засгийн газрын
 тохируулагч агентлаг
 СТАНДАРТ,
 ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
 Архивын эрхлэгч
 2010 оны 06 сарын 04 -ний өдөр

	Эталон төхөөрөмжийн зураг, шалгалт тохируулгын гэрчилгээний хуулбар	
	Хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зураг, шалгалт тохируулгын гэрчилгээний хуулбар	
	Үйлдвэрлэх, угсрах стандартын зураг, баримт бичиг, технологийн зааврын хуулбар	
	Үйлдвэрлэсэн хэмжих хэрэгслийн зураг, бүтэц үйл ажиллагаа, технологийн болон аюулгүй ажиллагааны заавар, бүтээгдэхүүнд олгогдсон холбогдох гэрчилгээний хуулбар, мэдээлэл	
5	Импортлох:	
	Хэмжих хэрэгслийг агуулах байр, өрөөний мэдээлэл, зураг	
	Импортлон худалдах, ашиглах ажиллагааны зааврын хуулбар	
	Хамтран ажилласан холбогдох мэргэжлийн засвар, үйлчилгээний байгууллагаас хэмжил зүйн үйл ажиллагааны чанар болон сэлбэг хэрэгслээр хангаж ажилласан эсэх тухай мэдээлэл	
	Импортлон худалдсан, ашигласан хэмжих хэрэгслийн болон шалгалт баталгаажуулалтад хамруулсан тухай бүртгэл, дэвтрийн зураг	
	Үйлдвэрлэгчийн танилцуулга, үйлдвэрлэгчтэй болон гэрээт борлуулагчтай байгуулсан импортоор нийлүүлэх, сэлбэг хэрэгслээр хангах тухай гэрээ, хэлцлийн чанартай баримт бичгийн хуулбар, баталгаат орчуулгын хувь	
	Сэлбэг хэрэгслийн жагсаалт, зураг	
	Хэмжих хэрэгслийн загварт олгогдсон холбогдох гэрчилгээний хуулбар, мэдээлэл	
6	Суурилуулах:	
	Багаж, тоног төхөөрөмжийн ороо, тасалгааны мэдээлэл, зураг	
	Суурилуулах технологийн зааврын хуулбар, схем зураг	
	Холбогдох стандарт, баримт бичгийн мэдээлэл, зураг	
	Хэмжих хэрэгслийг /үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, загвар, сери, дугаар, шалгалт баталгаажуулалтад хамрагдсан огноо/ хаана, хэзээ, хэн суурилуулсан бүртгэлийн дэвтрийн зураг	
	Суурилуулах ажиллагааны багаж хэрэгслийн зураг, шалгалт тохируулгын гэрчилгээний хуулбар	
	Суурилуулан хүлээлцэх актын загвар	
7	Засварлах:	
	Засвар, тохируулгын лабораторийн байрны мэдээлэл, зураг	
	Хэмжих хэрэгсэл хүлээн авах өрөө, тасалгааны мэдээлэл, зураг	
	Лабораторийн дүрмийн хуулбар	
	Засвар, тохируулгын эталон, тоног төхөөрөмжийн мэдээлэл, техник ашиглалтын бүртгэл, зураг	
	Эталон тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын гэрчилгээний хуулбар	
	Засварлах технологийн зааврын хуулбар	
	Холбогдох стандарт, баримт бичгийн мэдээлэл, зураг	
	Засварласан хэмжих хэрэгслийн /үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч	

Бүртгэлийн дугаар 88

ХУУЛБАР ҮНЭН

Төрийн Засгийн газрын
тохируулагч агентлаг
СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архийн эрхлэгч

М.М.М.

2020-ийн 06-арын 04-ний өдөр

	загвар, сери, дугаар/ хэзээ, ямар засвар, үйлчилгээг хэн гүйцэтгэсэн бүртгэлийн дэвтрийн зураг, мэдээлэл, засварын дараа шалгалт баталгаажуулалтад хамруулсан бүртгэл, дэвтрийн зураг	
	Засварлах ажиллагааны багаж, хэмжих хэрэгслийн мэдээлэл, зураг, шалгалт тохируулгын гэрчилгээний хуулбар	
	Сэлбэг хэрэгслийн жагсаалт, зураг	
8	Хэмжил зүйн үйл ажиллагааны хураамжийн төлбөрийг нэхэмжлэлийн дагуу төлнө. /..... банкны дугаар дансанд/	
Тайлбар:		

Жич: Энэхүү хуудсыг холбогдох баримт бичгийн хамт Хэмжил зүйн төв байгууллагад хүргэнэ.

Бармт бичгийг бүрдүүлсэн:

Ллбан тушаал:

Овог, нэр:

Гарын үсэг:

"....." ХХК-ийн төлөөлөгч

.....

..... Бүртгэлийн дугаар 88



Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2020 оны *06* сарын *04* -ны өдрийн
A/138 дугаар тушаалын хавсралт 3

..... /аймгийн, хотын/ /аж ахуйн
 нэгж, байгууллагын нэр/ -ийн хэмжил зүйн үйл ажиллагааны хамрах хүрээ

Д/д	Хэмжих хэрэгслийн				Хэмжил зүйн үйл ажиллагааны хэлбэр			
	Нэр	Загвар	Хэмжих хязгаар	Хөвшөөрөгдөх алдаа, нарийвчлалын анги	Үйлдвэрлэх	Итпортлох	Засварлах	Суурилуулах
0	1	2	3	4	5	6	7	8
Нэг. Хүндийн хэмжил								
1								
Хоёр. Цахилгааны хэмжил								
1								
Гурав. . . .								
1								

Боловсруулсан:

/Албан тушаал, овог нэр/

Жич: Хэмжих хэрэгслийн зургийг хавсаргана.

Бүртгэлийн дугаар *88*

ХУУЛБАР ҮНЭН
 Монгол улсын Засгийн газрын
 тохируулагч агентлаг
**СТАНДАРТ,
 ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**
 Архивны эрхлэгч
Анхуу
 20*20* оны *06* сарын *04* өдөр

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2020 оны *06* сарын *04* -ны өдрийн
A/138 дугаар тушаалын хавсралт 4

..... аймгийн, хотын/ "....." ХХК /аж ахуйн
 нэгж, байгууллагын нэр/ -ийн хэмжил зүйн үйл ажиллагаа
 явуулах ажлын байрны хангамж, тодорхойлолт

д/д	Ажлын байр, өрөөний									
	Зориулалт, нэр	Талбай, м ²	Температур, °C	Чийглэг, %	Гэрлүүлэг /байгалийн, хиймэл/	Дуу чимээ, чичирхийлэл	Тоосжилт ба бусад хортой нөхцөл байгаа эсэх	Нөхцлийг мэргэжлийн хяналтын байгууллагаар тодорхойлуулсан бол шийдвэрийн дугаар, огноо	Нөхцөл шаардлага хангана	Нөхцөл шаардлага хангахгүй
1										
2										
3										
4										
5										

Боловсруулсан:

/Албан тушаал, овог нэр/

Жич: Зориулалт бүхий ажлын байр, өрөө, агуулахын гэх мэт зургийг хавсаргана. *88*

ХУУЛБАР ҮНЭН
 Монгол улсын Засгийн газрын
 тохируулагч агентлаг
 СТАНДАРТ,
 ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
 Архивын эрхлэгч
В.Х.Түвшин
 20*20* сарын *06* сарын *04* ний өдөр

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
 2020 оны 06 сарын 04-ны өдрийн
 А/138 дугаар тушаалын хавсралт 5


..... аймгийн/хотын “.....” ХХК /аж ахуйн нэгж, байгууллагын нэр/ -ийн
 хэмжил зүйн үйл ажиллагаа явуулахад ашиглагдах ажлын эталон, тоног төхөөрөмжийн
 хангамж, тодорхойлолт

д/д	Эталон, тоног төхөөрөмжийн					Шалгалт тохируулгад хамрагдсан огноо	Баталгаажуулалт, шалгалт тохируулгын гэрчилгээний дугаар /хуулбарыг хавсаргах/
	Нэр	Загвар	Үйлдвэрлэсэн Улс, он	Хэмжих хязгаар	Зөвшөөрөгдөх алдаа, нарийвчлалын анги		
1							
2							
3							

Боловсруулсан:

/Албан тушаал, овог нэр/

Жич: Хэмжлийн эталон тус бүрийн зураг, шалгалт тохируулгад хамрагдсан
 гэрчилгээний хуулбарыг хавсаргана.



Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2020 оны 06 сарын 04-ны өдрийн
А/138... дугаар тушаалын хавсралт 6

..... аймгийн/хотын /аж ахуйн нэгж, байгууллагын нэр/ -ийн хэмжил
зүйн үйл ажиллагаа явуулахад ашиглагдах ажлын багаж, хэмжих хэрэгсэл, тоног
тохөөрөмжийн хангамж, тодорхойлолт

Д/д	Ажлын багаж, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн				Байгаа тоо ширхэг	Ашиглалтын бэлэн байдал /шалгалт тохируулгад хамрагдсан огноо/
	Нэр	Загвар	Үйлдвэр- лэсэн улс, он	Техникийн үзүүлэлт		
1						
2						
3						
4						
5						

Боловсруулсан:

/Албан тушаал, овог нэр/

Жич: Багаж, хэмжих хэрэгслийн зураг, шалгалт тохируулгад хамрагдсан гэрчилгээний
хуулбарыг хавсаргана.

Бүртгэлийн дугаар

ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
техник үйлдэгч агентлаг
СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын эрхлэгч
.....
2020 оны 06 сарын 04-ний өдөр

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2020 оны 06 сарын 04-ны өдрийн
А/138 дугаар тушаалын хавсралт 7

..... аймгийн/хотын. аж ахуйн нэгж, байгууллагын нэр/ -ийн
хэмжил зүйн үйл ажиллагаа явуулахад мөрдөж ажиллах хууль, дүрэм журам, стандарт
болон бусад норматив техникийн баримт бичгийн хангалт

д/д	Эрх зүйн актын нэр	Дугаар	Байгаа эсэх	Хүчин төгөлдөр, мөрдөгдөж байгаа эсэх
Нэг. Холбогдох хууль				
1				
2				
Хоёр. Стандарт				
1				
2				
Гурав. Хэмжих хэрэгслийн үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагааг зохицуулсан технологийн заавар, дүрэм, журам, техникийн баримт бичиг				
1				
2				
3				

Боловсруулсан:

/Албан тушаал, овог нэр/

Жич: Хэмжил зүйн үйл ажиллагааны технологийн заавар, журмыг холбогдох стандарт, техникийн баримт бичиг болон холбогдох салбарын байгууллагаас гаргасан дүрэм, журмыг үндэслэн боловсруулж, баталгаажуулсан байна. Хуулбарыг хавсаргана.

Бүртгэлийн дугаар 88

ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
тохируулагч агентлаг
СТАНДАРТ.
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын эрхлэгч
.....
20 2020 оны 06 сарын 04-ний өдөр

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2020 оны *06* сарын *04* -ны өдрийн
А/138 дугаар тушаалын хавсралт 8

..... аймгийн/хотын..... /аж ахуйн нэгж,
байгууллагын нэр/ -ийн хэмжил зүйн үйл ажиллагааг эрхлэн
явуулах хүний нөөцийн хангалт

д/д	Овог нэр	Албан тушаал	Мэргэжил, хэдэн онд ямар сургууль төгссөн	Боловсрол	Хэмжил зүйн чиглэлээр ажилласан жил, туршлага	Одоогийн албан тушаалд ажилласан жил	Хэмжил зүйн сургалтад хамрагдсан эсэх/огноо
0	1	2	3	4	5	6	7
1							
2							
3							

Боловсруулсан:

/Албан тушаал, овог нэр/

Жич: Хүний нөөцийн мэргэжил, мэргэшлийн үнэмлэх болон хэмжил зүйн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар, ажлын байрны тодорхойлолтыг хавсаргана.

Бүртгэлийн дугаар *88*

ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
тохируулагч агентлаг
**СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**
Архивын эрхлэгч
Мухамед
20*20* оны *06* сарын *04* -ний өдөр